



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/15/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Аудитор: П.Ариунзаяа
Утас: 261740 Цахим хаяг: ariunzayap@audit.gov.mn
Өлзийт экаунт аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Ч.Эрдэнэжав
Утас: 88117655 Цахим хаяг: auditulziit@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Зээлийн батлан даалтын сан, түүний үйл ажиллагаа	10
3.2 Сангийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ЗГ	Засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

“ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН
САНГИЙН” ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ЦОГТСАЙХАН ТАНАА

2025.03.25 № 01/1187
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зээлийн батлан даалтын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллага нь 13,261 харилцагчийн 624,054.5 сая төгрөгийн зээлд 370,908.4 сая төгрөгийн батлан даалт гаргаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

“Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” Засгийн газрын 166 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, орон нутагт 4 салбар нэгж байгуулахад түрээсийн зардалд 87.2 сая төгрөг, шуудан холбоо интернэтийн төлбөрт 4.2 сая төгрөг, хөрөнгө худалдан авахад 264.3 сая төгрөг, нийт 355.7 сая төгрөг зарцуулан ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитын явцад удирдлагын зүгээс цар хүрээ болон хангалттай, зохистой нотолгоо олж авахад аливаа хязгаарлалт үүсээгүй бөгөөд цаг тухайд нь аудитад шаардлагатай баримт материалаар хангаж ажилласан.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	186,852,736,031.06	250,433,741,593.21
1.1.4	Бусад авлага	27,581,234,154.38	19,679,969,532.66
1.1.6	Бараа материал	58,838,509.27	120,052,986.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,290,674,733.99	2,287,899,733.99
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	216,783,483,428.7	272,521,663,846.38
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,268,520,696.9	2,661,001,988.12
1.2.2	Биет бус хөрөнгө	33,885,867.66	22,813,640.09
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	40,000,000,000.00	35,000,000,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	42,302,406,564.56	37,683,815,628.21
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	259,085,889,993.26	310,205,479,474.59
2.1.1.1	Дансны өглөг	4,5143,09,973.58	342,654,247.56
2.1.1.3	Татварын өр	2,695,041.89	687.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	3,868,700	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	318,417,066.07	5,643,836,863.99
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	-	1,800,000,00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,839,290,781.54	5,988,291,798.55
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Урт хугацаат зээл	129,800,945,947.06	166,230,840,143.76
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	40,050,000,000.00	35,050,000,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	169,850,945,947.06	201,280,840,143.76
2.3.1	Өмч:-төрийн	60,000,000,000.00	60,000,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	17,249,037,052.59	24,763,037,052.59
2.3.9	Хуримтлагдсан ашиг	7,146,616,212.07	18,173,310,479.69
2.3.11	Эздийн өмчийн дүн	84,395,653,264.66	102,936,347,532.28
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	259,085,889,993.26	310,205,479,474.59

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	874,052,304.9	6,696,198,228.36
2	Хүүний орлого	11,071,635,772.9	19,850,383,914.5
3	Борлуулалт, маркетингийн зардал	86,031,426.23	240,029,657.11
4	Ерөнхий ба удирдлагын зардал	2,658,177,073.58	4,163,541,734.04
5	Санхүүгийн зардал	2,695,634,654.91	8,114,048,929.61
6	Бусад зардал	748,993,106.6	2,775,132.74
7	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(1,311,994.54)	197,604.68
8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	5,755,539,821.94	14,026,384,294.04
9	Орлогын татварын зардал	-	-
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,755,539,821.94	14,026,384,294.04

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	59,200,000,000.00	13,949,037,052.59	5,491,076,390.13	78,640,113,442.72
Залруулсан үлдэгдэл	59,200,000,000.00	13,949,037,052.59	5,491,076,390.13	78,640,113,442.72
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	5,755,539,821.94	5,755,539,821.94
Өмчид гарсан өөрчлөлт	800,000,000.00	3,300,000,000.00	(3,300,000,000.00)	800,000,000.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,000,000,000.00	17,249,037,052.59	7,146,616,212.07	84,395,653,264.66
Залруулсан үлдэгдэл	60,000,000,000.00	17,249,037,052.59	7,146,616,212.07	84,395,653,264.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	14,026,384,294.04	14,026,384,294.04
Өмчид гарсан өөрчлөлт	-	7,514,000,000.00	(7,514,000,000.00)	-
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	60,000,000,000.00	24,763,037,052.59	18,173,310,479.69	102,936,347,532.28

Зээлийн батлан даалтын сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	36,982,197,892.6	85,937,181,413.18
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	27,859,459,058.66	67,651,490,971.59
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	507,784,977.41	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	45,225,267	1,591,717,483.52
1.1.6	Бусад мөнгөн орлого	8,569,728,589.53	16,693,972,958.07
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,885,417,180.09	25,723,009,550.79
1.2.1	Ажиллагчдад төлсөн	869,630,762.75	8,269,013,588.77
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	385,501,597.61	559,446,296.59
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,394,797,983.41	1,402,550,735.37
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	199,172,085.38	69,175,727.06
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	734,473,741.71	1,947,440,222.16
1.2.9	Бусад мөнгөн зарлага	8,301,841,009.23	13,475,382,980.84
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	23,096,780,712.51	60,214,171,862.39
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,739,791,020.55	4,056,316,728.08
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	4,739,791,020.55	4,056,316,728.08
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	107,219,410.00	558,820,694.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	107,219,410.00	558,820,694.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,632,571,610.55	3,497,496,034.08
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(3,687,194.30)	-
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	1,450,108.23
3.2	Мөнгөн зарлагын дүн	(3,687,194.30)	132,112,449.21
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	2,394,100.00	130,859,939.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	1,293,094.30	1,252,510.21
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,687,194.30	132,112,449.21
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,725,665,128.76	63,581,005,562.15
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	159,127,070,902.30	186,852,736,031.06
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	186,852,736,031.06	250,433,741,593.21

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1.Нийт орлого	11,945,700,402.48	27,057,097,800.00	26,706,677,165.30	(350,420,634.70)	99.0
Батлан даалтын шимтгэлийн орлого	864,232,304.90	5,600,000,000.00	6,675,632,228.36	1,075,632,228.36	119.0
Хураамжийн орлого	9,820,000.00	20,000,000.00	21,666,000.00	1,666,000.00	108.0
Хадгаламжийн хүүгийн орлого	10,934,195,871.41	21,437,097,800.00	20,009,378,936.94	(1,427,718,863.06)	93.0
Үйл ажиллагааны бусад орлого	137,452,226.17	-	-	-	-
2.Нийт зардал	6,291,881,014.32	14,746,322,932.00	13,090,294,047.05	1,654,823,762.95	89.0
Цалин	1,655,877,098	2,907,658,514.00	2,437,025,445.05	470,633,068.95	84.0
НДШ	210,825,180	384,486,714.00	295,885,229.00	88,601,485.00	77.0
Нэг удаагийн тэтгэмж	147,610,885	137,120,000.00	13,900,000.00	123,220,000.00	10.0
Шагнал урамшуулал	126,000.00	7,610,000.00	6,951,600.00	658,400.00	91.0
Бичиг хэрэг	21,484,155	55,787,300.00	48,156,857.02	7,630,442.98	86.0
Шатах тослох материал	31,784,141	164,845,874.00	81,893,571.73	82,952,302.27	50.0
Хангамжийн материал	24,246,494	41,507,400.00	19,744,697.00	21,762,703.00	48.0
Гэрэл цахилгаан	4,824,631	-	-	-	100.0
Дулаан	6,443,455	-	-	-	100.0
Цэвэр бохир ус	1,006,474	-	-	-	100.0
Шуудан холбоо	11,059,690	22,413,600.00	20,587,253.27	1,826,346.73	92.0
Сэлбэг хэрэгсэл	-	59,174,000.00	6,951,600.00	52,222,400.00	12.0
Аж ахуйн материал	-	22,851,200.00	9,473,390.00	13,377,810.00	41.0
Байр ашиглалтын зардал	-	50,805,800.00	48,235,963.75	2,569,836.25	95.0
Томилолт (Дотоод)	39,747,018	294,232,000.00	231,148,638.00	63,083,362.00	79.0
Томилолт (Гадаад)	90,861,323	286,448,200.00	132,639,070.88	153,809,129.12	46.0
Засвар үйлчилгээ	57,516,028	138,810,400.00	117,617,448.50	21,192,951.50	85.0
Татвар хураамж	199,191,967	111,246,000.00	12,836,022.90	98,409,977.10	12.0
Түрээс	2,394,100	301,090,000.00	176,115,493.00	124,974,507.00	58.0
Маркетинг	86,031,426	255,422,000.00	240,029,657.11	15,392,342.89	94.0
Сургалт	23,564,500	150,750,000.00	117,709,508.00	33,040,492.00	78.0
Хяналт мониторинг	14,100,000	27,000,000.00	-	27,000,000.00	-
Хөрөнгө худалдан авах	88,079,410	620,941,000.00	558,820,694.00	62,120,306.00	90.0
Төсөл хөтөлбөр	732,577,198	-	-	-	100.0

**Зээлийн батлан даалтын сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

Зээлийн хүүгийн зардал	-	40,000,000.00	40,000,000.00	-	100.0
Даатгал	-	13,740,000.00	7,089,110.00	6,650,890.00	52.0
Аудит баталгаажуулалт	-	120,000,000.00	32,950,000.00	87,050,000.00	27.0
Банкны шимтгэл	-	1,122,000.00	2,763,132.74	(1,641,132.74)	246.0
Бусад зардал	-	52,600,000.00	46,281,199.14	6,318,800.86	88.0
Үзэсгэлэн арга хэмжээний зардал	-	209,612,000.00	120,717,350.00	88,894,650.00	58.0
Удирдлагын зардал	-	30,000,000.00	14,515,678.00	15,484,322.00	48.0
Элэгдлийн зардал	146,895,186	165,000,000.00	177,411,630.35	(12,411,630.35)	108.0
Дамжуулан зээлийн хүү амлалтын зардал	2,695,634,655	8,074,048,930.00	8,074,048,929.61	0.39	100.0
2. Нийт зардал	6,291,881,014.32	14,746,322,932.00	13,090,294,047.05	1,654,823,762.95	89.0
Татварын өмнөх ашиг, алдагдал	5,653,819,388.16	12,310,774,868.00	13,616,383,118.25		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Зээлийн батлан даалтын сан, түүний үйл ажиллагаа

Зээлийн батлан даалтын сан нь Улсын Их Хурлаас Зээлийн батлан даалтын сангийн хуулийг 2012 онд баталснаар үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа эхлүүлсэн байна. Тус сан нь ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд иргэн, хуулийн этгээд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд зээлийн батлан даалт гаргах үйл ажиллагаа явуулдаг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм..

Эрхэм зорилгоо “Барьцаа хөрөнгийн дутагдалтай Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршино” гэж тодорхойлсон байна.

Зээлийн батлан даалтын сан нь Удирдах зөвлөлийн 2024 оны 31 дүгээр тогтоолоор 66 орон тоотой ажиллахаар батлагдсан боловч тайлант жилд 52 ажилтантай үйл ажиллагаа явуулсан.

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангах хүрээнд орон нутагт 39 төлөөлөгчидтэй хамтран ажиллаж байна.

3.2 Сангийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” хөтөлбөрийн хүрээнд Хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүдийг хөнгөлөлттэй нөхцөл бүхий санхүүжилтээр хангах зорилгоор “Хөдөө аж ахуйг дэмжих зээлд батлан даалт гаргах чиглэлээр хамтран ажиллах гэрээ”-г Худалдаа хөгжлийн банктэй байгуулж техник тоног төхөөрөмж худалдан авахад хүүгийн хөнгөлөлттэй, худалдан авсан техникийг буцаах нөхцөлтэй зээлд хамрагдах боломж бүрдүүлж ажилласан.

Тайлант оны байдлаар 13261 харилцагчийн 624,054.5 сая төгрөгийн зээлд 370,908.4 сая төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зээлийн батлан даалтын сан нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 2022 оноос өмнө олгогдсон зээлд гаргасан 42 зээлдэгчийн 5,347.59 сая төгрөгийн чанаргүй батлан даалтын үлдэгдэлтэй байна. Тайлант оны байдлаар 2023, 2024 онд гаргасан батлан даалтууд чанаргүй ангилалд шилжээгүй бөгөөд чанаргүй батлан даалттай зээлийг зээлдэгчийн орлогын эх үүсвэртэй уялдуулж тодорхой хугацаанд төлүүлэх, барьцаа хөрөнгийг худалдан борлуулах зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна.

Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж талбайн явган хүний зам талбайг стандартад нийцсэн олон жилийн насжилттай байгалийн боржин чулуугаар шинэчлэх үндэсний үйлдвэрлэгчдийг хүүгийн хөнгөлөлттэй батлан даалттай зээлээр санхүүжүүлэхээр Нийслэлийн засаг даргын тамгын газартай хамтран ажиллах гэрээг 2024 онд байгуулж 5.6 сая төгрөгийн хүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийг хүлээн авч “Боржин чулуугаар үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн хүүгийн дэмжлэг үзүүлэх болон зээлийн батлан даалт гаргах гэрээ”-г Хаан, Худалдаа хөгжлийн банктэй байгуулж нэр бүхий 3 компанид олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166, 167 дугаар тогтоолын хүрээнд Уламжлалт мал аж ахуйн салбарыг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, малчны хамтын санаачилга, хоршоог дэмжих зорилгоор “Хоршооны гишүүн малчны зээл”-ийг Арилжааны

банкнуудтай хамтран ажиллах гэрээг 2024 онд байгуулж хоршооны гишүүн малчин иргэнд батлан даалт гаргаж ажилласан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ТБОНӨХБАҮХАТ хууль шинэчлэн найруулсан
- ЗГ-ын 2024 оны 128 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн батлах тухай";
- ЗГ-ын 2024 оны 2 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай";
- Зээлийн батлан даалтын сангийн дүрэм;
- Батлан даалт гаргах журам;
- Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
- Эрсдэлийн удирдлагын журам
- Сангийн хөрөнгө, мөнгөн хөрөнгийг удирдах, байршуулах журам;
- Зээлийн батлан даалтын хороо, зээлийн батлан даалтын дэд хорооны үйл ажиллагааны журам;
- Шинэ хоршоо хөтөлбөрийн зээлд батлан даалт гаргах журам;
- Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт батлан даалт гаргах журам;
- Батлан даалтаар хүлээсэн үүрэг гүйцэтгэх журам;

Сангийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ТУЗ-ын дэргэдэх хяналтын зөвлөл ажиллаж 6 зөвлөмж өгснийг, дотоод хяналтын ажилтан 2 чиглэлд 6 хяналт хийхээр төлөвлөж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Зээлийн батлан даалтын сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ТУЗ-ын 2022 оны 26 тоот тогтоолоор баталж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт
“Зээлийн батлан даалтын сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51,119.6 сая төгрөгөөр буюу 19.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянгаан төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	186,852,736.0	250,433,741.6	63,581,005.6
Авлага	27,581,234.2	19,679,969.6	(7,901,264.6)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	40,000,000.0	35,000,000.0	(5,000,000.0)
Урьдчилгаа	2,290,674.8	2,287,899.8	(2,775.0)
Бараа материал	58,838.6	120,053.0	61,214.4
Үндсэн хөрөнгө	2,302,406.6	2,683,815.6	381,409.0
Нийт хөрөнгө	259,085,890.0	310,205,479.5	51,119,589.5
Өр төлбөр	169,850,945.9	201,280,840.1	31,429,894.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	84,395,653.3	102,936,347.5	18,540,694.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	259,085,890.0	310,205,479.5	51,119,589.5

Нөлөө бүхий өөрчлөлт гарсан болон материаллаг их дүнтэй үлдэгдэл бүхий мөнгөн хөрөнгө, авлага, урт хугацаат хөрөнгө оруулалт, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 250,433.7 сая төгрөг болж 63,581.0 сая төгрөгөөр өссөн нь Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн санхүүжилт 36,429.8 сая төгрөгийг хүлээн авсан, шинэ хоршоо хөдөлгөөн өрнөж хоршооны гишүүн малчны батлан даалтын шимтгэлийн орлогод 5,510.2 сая төгрөг хүлээн авсан зэрэг нь голлох нөлөө үзүүлсэн.
- Авлагын дансны үлдэгдэл 19,679.9 сая төгрөг болж 7,901.3 сая төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгийн хадгаламжийн хүүгийн авлагыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 35,000.0 сая төгрөг болж 5,000.0 сая төгрөгөөр буурсан нь Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Хадгаламжийн даатгалын корпораци, Зээлийн батлан даалтын сангийн хооронд 2021 оны 12/02-02 дугаартай байгуулсан Үнэт цаас

худалдах, худалдан авах, түүнд батлан даалт гарган санхүүжүүлэх гэрээний төлбөрийг төлсөнтэй холбоотой.

- Урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл 2,683.8 сая төгрөг нь Сангийн яам, Зээлийн батлан даалтын сангийн хооронд 2016 онд байгуулсан 170/32 тоот дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу тооцсон зээлийн хүү, ашиглаагүй зээлийн үлдэгдэлд төлөх амлалтын шимтгэлийг хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой.
- Бараа материалын дансны үлдэгдэл 120.0 төгрөг болж 61.2 сая төгрөгөөр өссөн нь байгууллагын үйл ажиллагаа өргөжиж 4 салбартай болж, бүтэц орон тоо нэмэгдсэнтэй холбоотой.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,683.8 сая төгрөг болж 381.4 сая төгрөгөөр өссөн нь нээлттэй тендер шалгаруулалтаар 245.0 сая төгрөгөөр тээврийн хэрэгсэл, харьцуулалтын тендер шалгаруулалт, ерөнхий гэрээгээр, шууд аргаар 78,3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 58.1 сая төгрөгийн компьютер техник хэрэгсэл худалдан авсан нь нөлөөлсөн.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 201,280.8 сая төгрөг болж өмнөх оноос 31,429.9 сая төгрөгөөр өссөн нь Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн санхүүжилт 36,429.9 сая төгрөгийг хүлээн авсантай холбоотой.
- Эздийн өмч дансны үлдэгдэл 102,936.3 сая төгрөг болж 18,540.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 14.0 сая төгрөг үүрэг гүйцэтгэлийн өглөг дансны 4,514.3 сая төгрөгийн өглөгийг хааж өмнөх үеийн үр дүнд залруулах бичилт хийсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

ТУЗ-ын 2024 оны 66 тоот тогтоолоор байгууллагын 2024 оны үндсэн үйл ажиллагааны төсвийн орлогыг 27,057.0 сая төгрөг төлөвлөснөөс 26,706.6 сая төгрөг буюу 99 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Батлан даалтын шимтгэлийн орлого 5,600.0 сая төгрөг төлөвлөснөөс 6,674.5 сая төгрөг 119 хувь, Хураамжийн орлого 20,000.0 сая төгрөг төлөвлөснөөс 21,666.0 сая төгрөг 108 хувь, Хадгаламжийн хүүгийн орлого 21,437.1 сая төгрөг төлөвлөснөөс 19,939.4 сая төгрөг 93 хувийн биелэлтэй байна. Хадгаламжийн хүүгийн орлого буурсан нь батлан даалтын хэмжээ өссөнтэй холбоотой

Үндсэн үйл ажиллагааны зардалд 14,746.3 сая төгрөг төсөвлөснөөс 13,090.3 сая зарцуулж 89.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал болох төслийн зээлийн 2024 оны хүү, амлалтын шимтгэл, дамжуулан зээлийн шимтгэлийн төлбөрт 8,074.0 сая төгрөг төлсөн

Хөрөнгө оруулалтын зардалд 620.9 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 558.8 сая төгрөгөөр шаардлагатай хөрөнгүүдийг нээлттэй, харьцуулалт, ерөнхий гэрээ, шууд аргуудаар худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Зээлийн батлан даалтын сан-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Зээлийн батлан даалтын сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг сайжруулах бэлэн мөнгө, бараа материал, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өлзийт экаунт аудит ХХК-ийн ахлах аудитор Ч.Эрдэнэжав, аудиторын туслах Д.Мандахбаяр, Б.Лхагвасүрэн нар гүйцэтгэж, компанийн чанарын хяналтын менежер Ц.Бямбажав анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Г.Мөнхчимэг, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Зээлийн батлан даалтын сан-ийн 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн 01/146 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 11,945.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 119.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хязгаарлалтуудыг мөрдөж ажилласан эсэхийг холбогдох санхүүгийн баримт бичиг, тушаал шийдвэртэй тулган шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Дархан уул аймагт шилжихтэй холбогдон 39 сая төгрөгийн тавилга эд хогшил компьютер дагалдах хэрэгслийг худалдан авахдаа тендер шалгаруулалт зохион байгуулах буюу цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ". 14 дүгээр зүйлийн 14.4 "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийг иж бүрэн хэрэгжүүлж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 39.6 сая төгрөгийн зөрчил илэрч, түүнд 1 албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны сайтад мэдээлэх ёстой 157 мэдээнээс хугацаандаа мэдээлсэн 155 мэдээ, хугацаа болоогүй 2 мэдээ байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд шинээр гэрээ байгуулж, цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,524.6 сая төгрөгийн зөрчил илэрч давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснээс 4,518.6 сая төгрөгийн зөрчлийг бүрэн арилгаж 6,0 сая төгрөгийн зөрчил шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлж гүйцэтгэх шатанд байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	4,514,310.0	1	4,514,310.0	100
Зөвлөмж	2	10,300.0	2	10,300.0	85
Нийт дүн	3	4,524,610.0	3	4,524,610.0	

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс шийдвэр гүйцэтгэх шатанд байгаа 6.0 сая төгрөгийн авлагыг цуглуулсан эсэхийг дараагийн аудитаар анхааран үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 67.9 сая төгрөгийн зөрчилд ¹ 4 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн шинж чанартай 22.1 сая төгрөгийн зүйлсийг бараа материал дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-т "Бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх" гэж заасантай нийцээгүй, НББОУС-2-ын 37-д "Янз бүрийн ангилалд хамаарах бараа материалын дансны үнэ болон тэдгээр хөрөнгийн өөрчлөлтийн хэмжээний талаарх мэдээлэл нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг. Бараа материалын нийтлэг ангилал нь бараа, үйлдвэрлэлийн хангамжийн зүйлс, материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн юм" гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын бүртгэлд байгаа үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг шилжүүлэн бүртгэх

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

НБББББ-д заасан үндсэн хөрөнгийн элэгдлийн хугацааг баримтлаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 35.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг дараах байдлаар тооцно" гэж заасантай нийцээгүй, НББОУС-16 Үндсэн хөрөнгө-ийн 16.50-д "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилна" гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцох хугацааг баримтлан зардлыг үнэн зөв бүртгэх

3. Өртөг тооцохтой холбоотой асуудал

Орлогыг олж байгаа эх үүсвэрээр нь ангилан бүртгэж байна. Зардлыг олж байгаа орлоготой нь уялдуулж өртөг тооцолгүй ерөнхий удирдлагын зардлаар бүртгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцээгүй, СТОУС-ын Онолын үзэл баримтлалын 4.72 -т " Янз бүрийн гүйлгээ болон бусад үйл явдал нь өөр өөр шинж чанар бүхий орлого, зардлыг бий болгодог. Өөр өөр шинж чанар

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүхий орлого, зардлын талаар тусад нь өгөх мэдээлэл бол аж ахуйн нэгжийн санхүүгийн гүйцэтгэлийг ойлгоход санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах боломжтой мэдээлэл юм" гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Олж байгаа орлого буюу бүтээгдэхүүн тус бүрээр өртгийг тооцон төлөвлөлтийг сайжруулах

4. Цалин хөлсний бүртгэлтэй холбоотой асуудал

Батлагдсан цалингийн тооцоолол ХХОАТ-ын тайлангаас 1.8 сая төгрөгөөр дутуу, Даатгуулагчийн НДШ 8.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" гэж заасантай нийцээгүй, СТОУС-ын нийцэлд 15-д Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсний бүртгэлтэй холбоотой тайлангуудыг үнэн зөв бүртгэж тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр											
Үүнээс											
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
									Тоо	Дүн	
	Үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлс бараа материал дансанд бүртгэсэн байна.	1	22,092.4					1	22,092.4		
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 35.5 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.	1	35,554.8					1	35,554.8			
Зардлыг олж байгаа орлоготой нь уялдуулж өртөг тооцолгүй ерөнхий удирдлагын зардлаар бүртгэж байна.	1	-					1	-			
Батлагдсан цалингийн тооцоолол ХХОАТ-ын тайлангаас 1.8 сая төгрөгөөр дутуу, Даатгуулагчийн НДШ 8.4 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.	1	10,228.5					1	10,228.5			
Дүн	4	67,875.7					4	67,875.5			



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Дархан уул аймагт шилжихтэй холбогдон 39.6 сая төгрөгийн тавилга эд хогшил компьютер дагалдах хэрэгслийг худалдан авахдаа тендер шалгаруулалт зохион байгуулах буюу цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	39,650.5			1	39,650.5						
Дүн	1	39,650.5			1	39,650.5						



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 633/АД/50069

Улаанбаатар хот

Схвг-0025/015/нр-СТА-ТӨМГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зээлийн батлан даалтын сангийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Дархан уул аймагт шилжихтэй холбогдон 39,650,520.00 /гучин есөн сая зургаан зуун тавин мянга таван зуун хорин/ төгрөгийн цахим дэлгүүрт байршсан тавилга эд хогшлыг шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршуулсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим дэлгүүрт байршсан барааг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал /С.Цогтсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /Т.Пунсалдулам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
Э ЭНХБААТАР
Ч.ЭРДЭНЭЖАВ

This image shows a full page of primary-ruled paper. It features approximately 20 horizontal dashed lines spaced evenly down the page, providing a guide for handwriting practice. The paper is otherwise blank, with no margins, text, or other markings.

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс